



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар A/120

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны “Журам батлах тухай” 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжирааны зардлын зээл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны “Боловсролын зээлийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2018 оны А/368 дугаар тушаалын хавсралт дахь Батсүх овогтой Мөнхтуяад холбогдох хэсгийн “Portland state university” гэснийг “Pacific States University” гэж, 2017 оны А/125 дугаар тушаалын хавсралт дахь Дашидзорж овогтой Чингисхүүд холбогдох хэсгийн “University of Illinois at Chicago” гэснийг “Shinhans University”, 2017 оны А/125 дугаар тушаалын хавсралт дахь Мөнхдаш овогтой Олонбаяарт холбогдох хэсгийн “University of Technology Sydney” гэснийг “Purdue Northwest University”, 2015 оны А/155 дугаар тушаалын хавсралт дахь Баттэр овогтой Ганзоригт холбогдох хэсгийн “University of Michigan” гэснийг “University of Minnesota” гэж, 2016 оны А/112 дугаар тушаалын хавсралт дахь Дашидандог овогтой Гантөгст холбогдох хэсгийн “The University of Queensland Australia” гэснийг “The University of New South Wales” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /М.Ариунжаргал-/д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Олон улсын төсөл, хөтөлбөр, гадаад хамтын ажиллагааны газар /Т.Ууганбаяр/-т тус тус даалгасугай.

САЙД

Ё.БААТАРБИЛЭГ

